



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/ВЭГЧ

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн “Насан-Урт” өрхийн  
эрүүл мэндийн төвийн барилгыг  
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 166 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1133 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-091/580 тоот дүгнэлтийг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барихтай холбогдуулан Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах “Насан-Урт” өрхийн эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй нийт 36,968,400 /гучин зургаан сая есөн зуун жаран найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн “Насан-Урт” өрхийн эрүүл мэндийн төв /Ч.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 2,600,000 /хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлтэд хяналт тавьж ажиллахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн “Насан-Урт” өрхийн эрүүл мэндийн төв /Ч.Цэрэннадмид/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001171